

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/01/СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг Сайншанд сум)
2019 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийн үүргийг	
түр орлон гүйцэтгэгч:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг: injig78@yahoo.com
Аудитор:	Ц.Энхтуяа
Утас: 99042645	Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....	7
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	7
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	7
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	7
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	114

Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Бэл сайт: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА
2020.02.28 № 1-6/153 танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.	
Зөрчилгүй санал дүгнэлт	
Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-гийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.	
Санал дүгнэлтийн үндэслэл	
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.	
Аудитаар Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.	


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Дорноговь аймгийн Халамж үйлчилгээний газрын дарга Д.Цэндмаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй үр нөлөөтэй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.-д заасны дагуу Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/ 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ний аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/ 2019 оны санхүүгийн тайлан, жилийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-гийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай орлоготой болгох, ядуурлыг бууруулах Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/ -ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/ санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Finance, Wais, НЭВ программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-гийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-гийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд 18 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 8,939,394.7 мянган төгрөгөөс тооцон 78,787.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 78787.9 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой болно.

2.8. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих / тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 8,901,077.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 8,901,077.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 8,901,077.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Батлагдсан төсвийн дагуу 8,901,077.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого авсан байна.

Алдарт эхийн одонгийн мөнгө -17,280.0 мянган төгрөг хэмнэгдсэн нь тухайн онд багаас авсан мэдээлэл, шинээр одон авч буй эхчүүд материалаа ирүүлээгүйтэй холбоотой байна.

Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт -11,451.2 мянган төгрөг хэмнэгдсэн нь 1 хүн 2 үйлчилгээг зэрэг авах боломжгүй, зарим ахмад нас барсантай холбоотой байна.

Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж 20,259.1 мянган төгрөг хэмнэгдсэн нь тухайн ээж төрөх сараасаа эрт төрж төрсөн сардаа авах, дараагийн сараас цалинтай ээж хөтөлбөрт шилжсэнтэй, мөн хүүхэд эндэх, материалаа бүрдүүлж ирүүлээгүйгээс шалтгаалжээ

Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал 20,239.4 мянган төгрөг хэмнэгдсэн нь иргэн материалаа ирүүлээгүй болон тухайн хүүхэд 18 нас хүрээд хасагдсанаас шалтгаалсан байна.

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал 30,134.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь нийгмийн даатгалаас эрх үүсээгүй өндөр үнэтэй протезийн 75 хувь хөнгөлөөгүй ахмад болон оршуулгын тэтгэмж олгогдоогүйтэй холбоотой байна.

Халамжийн тэтгэвэр 43873,0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Бүрдмэл магадлал” шалгалтаар хасагдах, мөн нас барснаас шалтгаалсан байна.

Халамжийн тэтгэмж 15521,3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь ахмад, ХБИ (хөгжлийн бэрхшээлтэй иргэн) ХБХүүхэд (хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд) асаргаанаас хасагдсанаас шалтгаалжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт 38,269.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь өндөр үнэтэй протез, ортопед тусгай хэрэгсэл, оршуулгын зардал, рашаан сувилалд төлөвлөсөн хэмжээнд хүрч хамрагдаагүйтэй холбоотой байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хөтөлбөрийн төсвөөс 33,375.9 мянган төгрөг хэмнэгдсэн нь өрхийн мэдээллийн сангийн судалгаанд хамрагдаж, босго онооноос доогуур орх өрхүүд авсан ба тайлант хугацаанд тухайн хөтөлбөрт хамрагдаж байсан өрхүүдээс ажиллах чадвартай, орлоготой болсон өрхүүдийг Амьжиргаа дэмжих зөвлөлийн /АДЗ/ шийдвэрээр хассанаас шалтгаалсан байна.

2.9. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 0 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 292,933.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 292,933.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-гийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 95 мэдээллийг хугацаанд нь, 35 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.12. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 46,391.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-гийн - ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/-гийн -ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Халамжийн сан /Улсын төсвөөс санхүүжих/ нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

1.1 Илрүүлэлт:

2019 онд 275,551.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь төсвийн төлөвлөлт хийхдээ орон нутгийн хүн амын өсөлт, бууралт, сүүлийн 3 жилийн халамж үйлчилгээ үзүүлсэн дэмжлэг, хөнгөлөлтийн судалгаанд үндэслэж хийдэггүй, хэт өндрөөр төлөвлөснөөс шалтгаалсан байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Орлогын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Орлогын дэлгэрэнгүй бүртгэлийн сорилоор тооцооллын алдаа гаргаж буцаан оруулсан 17,381.3 мянган төгрөгийг буцаасан орлогоор тайлагнасан байна. /Үүнд жирэмсэн эхчүүдийн тэтгэмжээс 2,842.2 мянган төгрөг, цалинтай ээж хөтөлбөрөөс 2,383.4 мянган төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөөс нэр данс зөрсөн 3,200.0 мянган төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэгээс 1,891.1 мянган төгрөг/

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Орлогыг буруу бүртгэж тайлагнах.

2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нь staus.audit.mn программ хангамжтай уялдаагүй байна.

Энэ нь үнэн зөв байх, бодиттой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.2 Эрсдэл:

Тухайн байгууллагад ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нь Сангийн яамнаас тогтоосон шаардлагыг хангахгүй байх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
3101	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
310201	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
310201	Төрийн сангийн харилцах		
310202	Арилжааны банк дахь харилцах		
310203	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
33	АВЛАГА	0.00	0.00
33	Улсын төсвийн авлага		
33	Хувь хүмүүсээс авах авлага		
33	Байгууллагаас авах авлага		
33	Орон нутгийн төсвийн авлага		
33	Байгууллагаас авах авлага		
33	Хувь хүнээс авах авлага		
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.00
41.1	Өглөг		
4101	Хэлтэс хоорондын тооцоо		
410101	Байгууллага хоорондын тооцоо УТ		
410102	Байгууллага хоорондын тооцоо ОНТ		
410103	Хувь хүнд өгөх улсын төсвийн өглөг		
410104	Хувь хүнд өгөх орон нутгийн төсвийн өглөг		
410105	Байгууллагад өгөх ОНТ-ийн өглөг		
4	Урьдчилж орсон орлого		
41040101	Урьдчилж орсон орлого Улсын төсөв		
41040102	Урьдчилж орсон орлого Орон нутаг		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	00	00
41	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
41	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
51	Хуримтлагдсан үр дүн	00	0.00
510301	Өмнөх үеийн үр дүн	00	
5103010002	Өмнөх үеийн үр дүн орон нутаг	(00	
45	Тайлант үеийн үр дүн орон нутаг		
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	0.00
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	0.00

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	3,167,300,000.00	8,901,076,960.00
130302	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	3,167,300,000.00	8,901,076,960.00
14120	Бараа үйлчилгээний орлого	7,644,848.90	38,317,783.00
1401021	Улсын төсвийн хүүгийн орлого	4,098,632.90	19,637,173.06
	Улсын төсвийн бусад орлого	3,546,216.00	18,680,610.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,174,944,848.90	8,939,394,743.06
2603	Төсөвт төвлөрүүлэх	42,844,858.90	275,551,688.06
260302	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	42,844,858.90	275,551,688.06
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	3,132,099,990.00	8,659,011,205.00
2701021100	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт		2,615,686,990.00
2701021200	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт		888,268,700.00
2701010103	Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт		625,600,090.00
2701021500	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	12,750,000.00	420,630,025.00
2701021604	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт		208,429,890.00
2701022000	Жирэмсэн, нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт		260,123,850.00
2701024000	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт		525,632,100.00
2702010101	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	656,880,000.00	668,320,000.00
27020102	Ахмад дайчдад алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	40,782,910.00	37,948,790.00
2702010400	Насны хишиг	389,870,000.00	408,180,000.00
2701010700	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	1,869,568,050.00	1,764,985,950.00
2701010800	Өрх, толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал	162,249,030.00	226,960,580.00
2702020308	Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал		8,244,240.00
	Банкны шимтгэл		4,831,850.00
	Банкны шимтгэл УТ		4,831,850.00
2702020306	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл		4,831,850.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,174,944,848.90	8,939,394,743.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (		

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО		
130302	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	3,167,300,000.00	8,901,076,960.00
14120	Бараа үйлчилгээний орлого	7,644,848.90	38,317,783.00
1401021	Улсын төсвийн хүүгийн орлого	4,098,632.90	19,637,173.06
1401021	Улсын төсвийн бусад орлого		1,299,300.00
1401023	Улсын төсвийн буцаасан орлого	3,546,216	17,381,310
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,174,944,848.90	8,939,394,743.06
2603	Төсөвт төвлөрүүлэх	42,844,858.90	275,551,688.06
260302	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	42,844,858.90	275,551,688.06
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	3,132,099,990.00	8,659,011,205.00
2701021100	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт		2,615,686,990.00
2701021200	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт		888,268,700.00
2701010103	Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт		625,600,090.00
2701021500	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	12,750,000.00	420,630,025.00
2701021604	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт		208,429,890.00
2701022000	Жирэмсэн, нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт		260,123,850.00
2701024000	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт		525,632,100.00
2702010101	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	656,880,000.00	668,320,000.00
27020102	Ахмад дайчдад алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	40,782,910.00	37,948,790.00
2702010400	Насны хишиг	389,870,000.00	408,180,000.00
2701010700	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	1,869,568,050.00	1,764,985,950.00
2701010800	Өрх, толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал	162,249,030.00	226,960,580.00
2702020308	Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал		8,244,240.00
	Банкны шимтгэл		4,831,850.00
	Банкны шимтгэл УТ		4,831,850.00
2603	Төсөвт төвлөрүүлэх	42,844,858.90	275,551,688.06
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	42,844,858.90	275,551,688.06
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,174,944,848.90	8,939,394,743.06

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	00	00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	00	00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	00	00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	00	00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			0	0
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Сангийн үйл ажиллагааны зардал	3,167,300,000.00	3,128,553,774.00	8,901,076,960.00	8,663,843,055.00
3	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	670,000,000.00	656,080,000.00	685,600,000.00	668,320,000.00
4	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн олгох тэтгэмж, тусламж хөнгөлөлт	41,000,000.00	40,782,910.00	49,400,000.00	37,948,790.00
270201	Насны хишиг	390,650,000.00	389,870,000.00	410,000,000.00	408,180,000.00
6	Халамжийн сан			8,250,000.00	8,244,240.00
	Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж			280,383,000.00	260,123,850.00
7	Банкны шимтгэл			5,300,000.00	4,831,850.00
9	УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ			8,901,076,960.00	8,663,843,055.00
10	Тохируулга				
	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	1,878,000,000.00	1,866,821,834.00	1,768,000,000.00	1,764,985,950.00
	Өрх, толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал	167,400,000.00	162,249,030.00	247,200,000.00	226,960,580
11	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал	20,250,000.00	12,750,000.00	450,764,000.00	420,630,025.00
	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт			2,659,560,000.00	2,615,686,990.00
	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт			903,790,000.00	888,268,700.00
	Онцгой тохиолдлын			627,122,560.00	625,600,090.00

	болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт				
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт			246,699,400.00	208,429,890.00
	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт			559,008,000.00	525,632,100.00